



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 02 дугаар сарын 27

№ 01/42 ДУА-2018/38/СТА-ТЦЗ Мандалговь хот

Г Т Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар салбарын тэргүүний ажилтны дагалдах шагналын хэмжээг 50,000.00 /тавин мянган/ төгрөгөөр хэтрүүлэн олгосон.

Энэ нь Засгийн газрын 142 дугаар тогтоолын 1-т /1997 оны 52 дугаар тогтоолын I дүгээр хавсралтаар баталсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн нийтлэг тодорхойлолт ба дагалдах монгён шагналын хэмжээ”-ний I дэх хэсгийн “Монгол Улсын сайд” гэснийг “холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга” гэжс, 2 дахь хэсгийн “30000 (гучин мянга)” гэснийг “100000 (нэг зуун мянга)” гэж тус тус өөрчилсүгэй/, Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.7-д /Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нохцол байдал/ заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Илүү олгосон тэргүүний ажилтны дагалдах мөнгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Төрийн сангийн **100080000955** дугаар дансанд 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор тус тус төвлөрүүлэх;
- Дотоод журмын холбогдох заалтыг Засгийн газрын тогтоолын дагуу өөрчлөх;

3. Актын биелэлтийг 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг төсвийн шууд захирагч Ц.Мөнгөнцож, нягтлан бодогч Д.Сольхүү нарт хариуцуулав.

### АКТЫГ

<b>ТОГТООСОН<sup>1</sup>:</b> АХЛАХ АУДИТОР  Т.БАТСАЙХАН  4217144713 ЗЮАРДЗУН 9034013	<b>ЗӨВШӨӨРСӨН:</b> ДАРГА  Ц.МОНГӨНЦОЖ НЯГТЛАН БОДОГЧ  Д.СОЛЬХҮҮ  ЗКА0007 9034013
--	--

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангаадаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцаач албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.